



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Хариуцлага тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг зөрчиж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Л.Энхбаярын албан тушаалын сарын үндсэн цалинг 2 сарын хугацаагаар 20 хувиар бууруулсугай.

2. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүрэг, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Л.Энхбаярт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000236